

Монгол дом

Б. Пүрэвсүрэн

Өдгөө монгол домын судалгаа төдийлөн үгүйн дээр монгол дом бол өрнөдийн судлаачдын үздэгээс өөр байх тул энд монгол домын талаар цухасхан боловч бичихийг хичээсэн бөлгөө.

Монгол бол Төв Азийн нүүдлийн соёл иргэншлийн баян өв уламжлалтай улс бөгөөд түүний салшгүй хэсэг бол эмчилгээний дом юм.

Эмчилгээний дом гэдэг нь бие махбодод ямар нэг хэмжээгээр нөлөөлж байдаг гэхдээ тэгж нөлөөлдгийн нууц нь тэр бүр бүрэн илрээгүй ардын анагаах арга мөн. Эмчилгээний домын үйлчилгээний механизм тодорхой болоогүйн улмаас ид шид, далдын хүчинд итгэх төөрөгдөлд хүргэж болох онцлогтой байдаг.

Дом нь хүн төрөлхтний өнө эртний түүхэн нөхцөл дэх соёл, танин мэдэхүйн онцлогтой холбоотой тул түүнийг бидний өвөг дээдэс болох эртний хүний тухай балар эртний түүхэн романд гардаг үйл явдлаас улбаалан тайлбарлаж болох юм.

Тухайлбал эртний монгол нутагт суурьшиж байсан хүний амьдралын түүхийг дүрслэн үзүүлсэн академич Б. Ренчиний зохиол 1966 онд хэвлэгдсэн “*Заан Залуудай*” гэдэг романы хэсгээс дурдвал уг зохиолын баатар Шонхлой яаран сүх, нум сумаа шүүрэн тэр эмэгтэйн заасан зүгт шамдаж очтол, сөөг боролж дунд нэг том шар эрээн юм үзэгдэж, амандаа нэг амьд эмэгтэйг зуугаад хүнээс огт айхгүй явах нь үзэгдэв. Барын аман дахь тэр эмэгтэйг үзвээс хүн хараад юм хэлж хашгирах нь амь авар гэж байгаа хөөрхий бололтой. Шонхлой ухасхийн тэр барын зүг яаран давшваас, хойноос нь Залуудай, Гекүү хоёр гүйж, сум харвах газар ойртохтой зэрэг гурвуул харваж, хойноос нь бас Үхүү ирэн бас хашхиран харвасанд, дөрвөн сум цөм тэр барсын гэдэс зоонд шигдлээ. Барс амандаа зууж явсан тэр эмэгтэйг газар хаяад хурхиран эргэж дөрвөн анчны зүг дайран орох гэлээ. /номын 43-44 дэх тал/

Энэ мэт араатан махсаг амьтны довтолгоонд эрсдэж, амьтны идэш болох нь тэр үеийн хүнд хэвийн үзэгдэл байсан болов уу.

Мөн романы “Махчинтай тулалдсан нь” гэдэг 27-р бүлэгт зохиолын баатрууд Гекүү яаран Бияагийнхаа дэргэд гүйж очоод хүлээсий нь огтчих гэж оролдож байтал баруун хөхөн тушаагаа сум хадаастай тэр махчны ахмад чийрэг эр өндийн босоод...Гекүүгийн араас жадлах гэтэл, Залуудай яаран ухасхийж, сүхээрээ тэр чийрэг эрийн эгмийг тас цавчтал, араас нь нэг хүнд юм лүс хийж буугаад, дээрээс нь нэг хүнд зөөлхөн юм дараад унах шиг болж, даруй нүд харанхуйлан ухаан алджээ. Хичнээн хэвтсэнийг бүү мэд, нэг мэдэхнээ түүдгийн дэргэд хэвтэж, хажууд нь нэг үхсэн дайсан алдлан сунаад, Шонхлой, ойн эмсийн эгчмэд, Үхүү гурав тэнхрүүлэн илж суунам. Энд тэнд унаж дуссан дайсны хүүр үзэгдэн, хэдэн эмс шархаа боож суунам. Гекүү газар сууж, дэргэд нь Бида сувилан оролдож байгаа бололтой, нуруу зоогий нь барьж байна. /романы 76 дахь тал/

Балар эртний үед нэг бүлийн сүрэг хүн арайхийн идэх юмтай болж, ангаа төхөөрч, байтал өөр нэг бүлгийн сүрэг хүн хүч түрэн дайрч, идэш хоолы нь булаах гэтэл амь өрссөн тулаан болж тэд дийлсэн ч олон хүн шархдаж, үрэгдэж, шархтай нэгийгээ сувилж, тэнхрүүлэхээр илж, барьж, цус тогтоож боодог домьг бие биедээ хийдэг үйл явдлыг романд ойлгомжтой, үнэмшилтэй тусгаж, тэр үеийн хүнд тохиолддог аюул хөнөөлийн хоёр дахь шалтгааныг харуулсан байна.

"...Гурын хааг чулуун хутгаар чадамгай эвдэж, нуурын бор давс, уулын сонгино хийгээд хатаамал мөөг нухаж, нунтаглан цулхирын үр хийж, тун аятайхан үнэр ханхалсан шөл чанаж, махаа шүүрхий шиг байгаа тун сайхан амтан дээр нь гаргаж, тэвшинд хийгээд эгчмэд эмгэний өмнө тавив. /70-р тал/ Ота өвс таньдаг сүрхий хүн та нарын дунд бий юм байна. Бодвол та байлгүй дээ? Гэж Шонхлойгоос асууваас би эмт өвс бага зэрэг танина гэж хариулав. Манай их отог гэдэг Цахиурчны Погпоон дүүг сайхан аргалжээ. Шархны халуун болдгийн даваан дээр та нартай дайралдаж, амь гарсан хүн байна. /"Заан Залуудай" 1966 зохиолын 11 дэх тал/

Романы энэ хэсэгт эртний монгол дом засалд эмийн ухаан бий болж, эмт ургамал таньдаг нэг нь бусдадаа тус хүргэдэг болсон үеийн үйл явдал гарчээ. Зохиолын энэ хэсэгт үйл явдал нь эмчилгээний домд эм, эмчилгээний салбартай болж, домын цар хэмжээ тэлсэн явцаас нэгэн тохиолдолд болсон явдлаар үзүүлжээ.

Эртний хүний тулаан, тэмцэлтэй амьжиргааны түгшүүрт орчин нөхцөлд яс мах тасарч, гэмтэж бэртэх, цус асгаран тэсэхүйеэ бэрх өвдөж шаналах, халуурч дэмийрэн, байх суух аргаа барьж ядахдаа шархаа долоох, алгаараа дарах, шархирч өвдсөн биеэрээ хад модонд шөргөөх, дарж хэвтэх, өөрийн эрхгүй хөдөлгөөн хийдэг тийн байгалийн авьяас, хамгаалах рефлексийн үйлдлүүд бол тэр цагийн хүмүүсийн дом байлаа.

Хожим дом нь бариа засал гэдэг аргатай болж, домын нэг салбар үүсжээ. Домын эх үүсвэр болох хамгаалах рефлексийн чадвар адгуус амьтанд ч байдаг. Чоно, нохой шархаа долоож, хандгай буга эмт ургамлын навч өгүшин /нутгийн нэр нь хандгайн шархны эм/ дээр хэвтэж эдгэрдэг, хэрэм хөлөө хугарахад модны давирхайгаар шавдаг /чиг тавьдаг/, хавханд орсон чоно хавхныхаа доод талаар хөлөө тас хазаж, хавхыг суга татаж орхиод явдаг зэрэг жишээ бий. Хүн бол хамгаалах чадвартаа үндэслэн сэтгэж хөгжүүлсэн туршлагаа хуримтлуулж бусаддаа уламжилсан оюун ухаанаараа бусдаас ялгаатай байдаг.

Эмчилгээний дом үүсэх эхэн үеийн түүхэн тойм ийм байсан буй.

Балар эртний хүний бүлээрээ сүрэглэн амьдардаг нөхцөл өөр болж, оюун ухааны хөгжил сайжирч, танин мэдэхүйн сэтгэлгээ нэмэгдсэний дүнд бүлээрээ сүрэглэж амьдардаг хүний амьдрал өөрчлөгдөж, бүлийн дотор хөдөлмөрийн хуваарь буй болж, эрэгтэйчүүд ан гөрөө хийх, сүргээ хамгаалахад давамгайлан орж, отог нутгаа сахиж, хүүхдээ бойжуулахад эмэгтэй хүн илүү оролцох болсноор оромж урц сахисан эмэгтэйчүүд хүүхдийн өвчнийг эмчлэх, эхнэрийн төрүүлэх, шархтанг сувилах зэрэг ажлыг гардан хийдэг болж, тэр цагаас эхлэн эмч, домч эмэгтэйчүүд олширч байсны сацуу монгол домд мэргэжлийн чиг ялгаа үүсээд дом - домч, эм - эмч, бариа - бариагч, хануур - хануурч гэдэг тусгай нэр томьёо бий болжээ.

Өнө эртний хүмүүс өвс ургамлыг хүнсний оронгоор хэрэглэж байсны дүнд зарим ургамал эдгэрүүлэх чадалтайг ажиг мэдээд, эм болгон эмчилгээнд хэрэглэх болсон цаг нь бариа заслаас их хойно үүссэн аж.

Эрүүл, өвчин, эдгээх гэсэн гурван үгийг эртний монголчууд эрүүл биеийг бүтэн, өвдсөн биеийг эвдэрсэн, эдгэрсэн биеийг зассан гэж ойлгодог байснаас улбаалан худам монголоор бичихдээ өвчтөн гэдгийг эвд+чин гэж бичдэг болсон сэтгэлгээний логик, танин мэдэхүйн тухайн үеийг илэрхийлсний баримт болж үлджээ. Эрүүл бие бүтэн юм бол өвдөхдөө эвдэрдэг, эвдэрсэн юм бол бүтэн болгохоор засна гэж сэтгэж өөр хоорондоо салшгүй утга уялдаатай үйл явдлаас ухааран өгсөн нэр байж болно. Өөрөөр хэлбэл засал гэсэн нэр бол бэртэл гэмтлийг эвлүүлэн барьж засна гэсний илэрхийлэл болно.

Энэ утгаараа эм эмчилгээ гарахаас өмнө засал гэсэн нэр томъёо буй болсныг харуулдаг. Засал гэдэг нэр томъёо гарсан тэр цагт бэртэл их тохиолддог байснаас өвдөж зовохыг эвдэрлээ гэж ойлгодог байжээ. Ийнхүү эмчилгээний домд мэргэжлийн салбарууд үүсэж өргөжсөн тэр үеэс эмчилгээний дом эмпирик хандлагатай болж, түүхийн урт хугацаанд тэр чанараа хадгалсан байна.

Нүүдлийн аж амьдралтай эртний монгол туургатан бэлчээр нутгаа хайрлаж, байгалийн аясыг дагаж зохицон амьдардаг байсан нь "дэлхий тэнгэр дэвжид найман аймаг минь ээ" хэмээн лус-уул, усны эзнийг аргадаж сүү цайныхаа дээж өргөдөг ёс буй болсны сацуу хүмүүст газар нутгаа хайрлан хамгаалах, байгальд чин сэтгэлээсээ хандах хүмүүжил төлөвших нөхцөлийг бүрдүүлсэн байна. Хүмүүст байгалийг шүтэх сэтгэлгээ бий болсноор байгальд гамгүй хандахыг хязгаарладаг сайн талтай байжээ.

Хүннүгийн үеэс нааш монголчууд цагаан өнгө бэлгэдэх болж, хаад язгууртнууд баяр ёслолд цагаан дээл өмсөж, цагаан морь унадаг болсон аж. Монгол хүний цагаан өнгөний бэлгэдэл нь малын сүүтэй холбоотой гэж зарим эрдэмтэн тайлбарладаг юм. Монгол хүн сүү асгаж эндэхдээ хуруугаа дүрж магнайдаа түрхдэг, алсын замд гарахдаа дөрөөгөө сүүгээр мялаадаг заншил бас сүүтэй холбоотой.

Монголчууд бас цээр гаргахад цагаан өнгөний бэлгэдэл хэрэглэж, харыг цагаанаар хариулах, гамшигт өвчин тахал, байгалийн бэрхшээлд эрсдэх үед гамшгийн нэрийг цээрлэж, цагаан бурхан, цагаан ханиад, цагаан цэцэг гэж байгалийн эрсдэлээс үхэл эндэлгүй гарвал цагаан мөртэй гэж нэрлэдэг байж.

Бас мал эмнэлгийн домыг түршилтын сорилго болгож хэрэглээд эдгээх сайн аргыг шилж олдог байсан учраас тэр аргаа сайн болоосой хэмээн мөрөөдөж цагаандом гэж нэрлэдэг байжээ. Хүний домыг "хардом" гэдэг. Хардом гэдэг нэрийг бэлгэдлээр биш өнгө заасан тэмдэг нэрийн утгаар биш "жинхэнэ" ардын гэдэг утгаар өгсөн нэр.

Буддын шашин монголд дэлгэрсэн тэр цагаас эхлэн лам бус энгийн ардыг хар хүн, тэрийн хар хүн гэж нэрлэдэг болж, ардын оюуны бүтээл болох "хардом"-ыг бурхны юм биш, харын зүгийн юм хэмээн ялгаварласан нь чухамдаа хардом гэдэг нэрийн агуулгыг жинхэнэ ардын гэсэн утгатай болохыг тодруулжээ.

Нүүдэлчний ахуйн шаардлагад нийцүүлэн цагаандом, хардом хоёрыг хамтад нь бичиж, тэр хоёр төрлийн домыг яарсан үед олоход амархан болгож хадгалах зориулалтаар нэг дэвтэрт багтаасныг "алагдом" гэдэг болсон байна.

Монголчууд домын судар номоо нүдэнд ил байлгах гэж гэрийн хоймор талын унинд хавчуулж, хүн малд яаралтай тусламж үзүүлэх цагт бэлэн ухасхийн авахад зориулсны улмаас ил хадгалах болжээ.

Хардом, цагаандомын зорилго нь хүн, малын эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс сэргийлэхэд чиглэсэн байдаг. Монгол домд эмчилгээний дом голчлон хөгжсөний сацуу, танин мэдэхүйн холбогдолтой шашны, зөн билгийн, сайн муу ёрыг домнох, Түвдийн эмнэлгийн ёс тарни, саег (ᠰᠠᠭᠡᠨᠢᠨᠳᠡᠭ ᠤᠰᠡᠭ гэсэн түвд үг.) зэрэг монгол домын төрөл бий болсон байна.

Нийгмийн зохион байгуулалттай эмнэлэг, сургууль, эмч мэргэжилтэн байгаагүй үед эм, домын арга, эмч, домч хүмүүс, хүн малын эрүүл мэндийг хамгаалахад чухал үүрэгтэй байсныг үгүйсгэх аргагүй юм.

Эм домын ёсыг дагалдаж, эмч домч, өвчтөний харилцааны ёс төлөвших, эрүүл мэнд, эмнэлгийн холбогдолтой заншил бүрдэж хэвшихэд үндэсний онцлогтой асаргаа, сувилгааны уламжлал бий болсон байна.

Эмнэлгийн ажилтан /эмч, домч, бариач/-ы эмчилгээ үйлчилгээний чанар, хөдөлмөрийг үнэлж дүгнэхдээ эртний монголчууд үйлчлүүлсэн хүн /өвчтөн/-ий баярласан сэтгэлийн үнэлэмжээр хэмжиж, "алтан гартан", "дахин амьдруулагч", "ачтан", "алдарт эмч", "алдарт бариач" хэмээн өргөн олны өргөмжилж өгсөн нэрээр нийтэд аяндаа алдаршдаг байжээ.

Бас ардын материаллаг урамшил нь "харамж" байсан бөгөөд түүний агуулга нь юмны үнэнд гол нь биш, өвчтөний баярлаж талархсаны илэрхийлэл, тэр хүний хамгийн сайн хийсэн юмны дээж, харамгүй сэтгэлээр өгсөн бодит дурсгалын билэг тэмдэг, эмчийн хөдөлмөрийн үнэлгээ болдог байжээ. Үхлүүт өвчтэй байсан хүн, эмчлүүлэхдээ хөрөнгө чинээнийхээ хэрээр ангийн арьс, хурганы арьс, хурга, төлөг, морь, тэмээ, аль өгье гэснээ харамгүй сэтгэлээр эмчид өгдөг, өгөх юмгүй гар хоосон нэг нь эдгэсний дараа өөрийн чадах зүйлээ ур, сэтгэмжийнхээ дээдээр үйлдэж, хэт, хутга, тунгийн халбага, хануурын хутга, тоногтой бүс, хөөрөгний даалин, аяганы уут зэрэг гоёлын ур шилсэн чамин зүүсгэл хийж "дахин хүн болгосон ачтан" хэмээн хүндэтгэж харамж болгон эмчид өгдөг заншилтай байжээ.

Хамгийн сайн эмч, домчийн эдлэл хэрэглэл нь нүд булаам гоёмсог цэвэрхэн хийцтэй онцгой харагддаг байсан гэдэг.

Эмч домчийн харилцааны ёс, эмч өвчтөний харилцааны ёс ч бас хардомд бий болж мөрдөгдөж байжээ. Тэдний хоорондын харилцаанд хэлдэг хэвшмэл үгтэй болсон байдаг. "Эм, Дом", "Хэзээ өвдөж, хэзээ домнуулан билээ", "Сумнаас хурдан, өднөөс хөнгөн" гэх мэт хэвшсэн үг хэлж өвчтөний анхаарлыг сарниулах, тайтгаруулах, эдгэрэх итгэл төрүүлэх арга хэрэглэдэг ёстой байжээ.

Хардом бол нүүдлийн соёл иргэншлийн салшгүй хэсэг, ардын уламжлалт анагаах ухааны анхны бөгөөд өвөрмөц онцлогтой хэсэг юм. Хардом бол бүхэлдээ нүүдэлчний аж байдлыг агуулан харуулсан онцлогтой байдаг. Үүнд:

1. Анхны тусламжийг цагт нь үзүүлдэг, бэлэн байх шаардлагад яв цав тохирсон байна.
2. Тусгай байр, багаж төхөөрөмж шаарддаггүй.
3. Эмнэлгийн ажилтан, өвчтөний алинд ч төвөг чирэгдэл бага байна.
4. Дан байгалийн бүтээгдэхүүн /амьтан, ургамал, эрдсийн гаралтай/ хэрэглэдэг.
5. Хамгийн бага зардалтай.
6. Хэрэглэхэд хамгийн хялбар байдаг.
7. Малд хийсэн сорилт туршилтаар сонгогдсон аргад түшиглэсэн онцлогтой байна.

Нүүдэлчний иргэншилд үүссэн учраас нүүдэлчний эмнэлэг, соёл гэж монгол домьг үзэх бүрэн боломжтой юм.

Домын сургалтын арга нь гэрийн багш шавийн хэлбэрээр эм дом мэддэг хүмүүсийг дагаж сурдаг байжээ. Гарын эв дүйтэй хүн бүр суралцаж дом хийдэг байх нь нүүдэлчдэд зайлшгүй шаардагдаж байдаг. Домын сургалтын дадлагад мал амьтныг хэрэглэж, малын эм дом бариа заслын аргад суралцсаны дараа хүний эм дом хийдэг дараалал бүхий уламжлал тогтсон байжээ.

Эмчилгээний дом бол анхнаасаа суурингийн биш, нүүдлийн нөхцөлд үүсэж буй болсон бөгөөд аян замд тохиолдсон өвчин зовлонд учирсан хүн өөрөө өөртөө, эсвэл хамт яваа хүн нь нэгэндээ тусалдаг нь яахын аргагүй шаардлага байдаг. Үүнээс өөр аргагүй юм. Иймд домын үүсэж хөгжсөн хэлбэр нь нүүдэлчний аж байдлын шаардлагаас урган гарч аяндаа бий болсон, өөрөө өөртөө буюу өрөөл бусдад үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламжийн хэлбэрээр үүсэн хөгжжээ.

Түүхийн урт хугацаанд монгол дом амаар дамжиж, улмаар бичиг үсэг бий болсон үеэс бичгийн уламжлалтай болж дэлгэрсэн байна. Энэ хоёр замаар уламжилж ирсэн монгол дом бол өнө эртнээс өлгөө хүртэлх монгол анагаах ухааны үр хөврөлийг агуулж иржээ.

Монгол домд гадаад орнуудын соёлын нөлөөгөөр шинэ урсгал бий болдог байжээ. Түвдийн шашны нөлөөгөөр саег тарнийн урсгал буй болсон байна. Үүний сацуу түвд эмнэлгийн зарим арга нэвтэрч монгол домьн онол, эмчилгээний арга барилд ахицтай нөлөөлсөн байжээ.

Өвчний шалтгаан нөхцөл эмчилгээний асуудалд халуун хүйтний онолын сэтгэлгээг гүнзгийрүүлж боловсронгуй болгосон нь монголчуудын онолын сэтгэлгээнд оруулсан хувь

нэмэр мөн. Монгол орны эрс тэрс уур амьсгалтай, дөрвөн улирлын хувиралтай, цаг агаарын нөхцөлд бэлчээрийн мал аж ахуй эрхлэн ажилладаг нүүдлийн хүмүүст хүйтний нөлөөгөөр үүсдэг өвчин эмгэг тусах нь багагүй байдгаас түүний эсрэг эмчилгээ урьдчилсан сэргийлэх аргыг монголчууд олон зууны урьдаас бодож олсноор арга билгийн онолд тохирсон хүйтний эсрэг халууны нөлөөг ашиглах аргаар төөнө заслыг үүсгэн хэрэглэж хөгжүүлсэн байна.

Төөнө заслын онолын үндэс нь арга билгийн онолд тулгуурласан байдаг. Төл мал, хүүхэд чацга алдахад халуун жин, төөнө, амьтны биеийн дулаан, нэмнээ бигнүүр зэрэг монгол домын дулааны нөлөөг ашиглаж хийдэг эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга нь анатоми, физиологийн үндэстэй шинжлэх ухааны арга байсныг биологийн ухааны доктор Шагжийн нээлтийн дашрамд батлагдсан билээ. Энэ мэтээр монгол домын эмчилгээний зүйлд онолын үндэслэл нь нотлогдох арга цөөнгүй байгаа нь судалгааны ач холбогдолтой юм.

Монгол домын эмчилгээ, урьдчилан сэргийлэх аргын онолын үндэслэлд дорно дахины гүн ухааны таван махбодын онол чухал байр эзэлж байжээ. Байгаль цаг уурын хатуу нөхцөлд бэлчээрийн мал аж ахуйн орчинд амьдардаг монголчуудын танин мэдэхүйд бодит өөрчлөлт гарч, өвчин эмгэгийг байгаль цаг уурын нөхцөлтэй холбож ойлгодог байжээ. Бас монгол хүний танин мэдэхүйн сэтгэлгээний хөгжилд таван махбодын онол их нөлөөлсөн гэж үзэх бүрэн боломжтой байна.

Үүний үрээр эртний монголчууд таван махбод "арга билиг" хэмээх дорно дахины гүн ухааны онолын сургаалыг монгол орны онцлогт тохируулан бүтээлчээр хэрэгжүүлсэн байна.

Эртний хүний амьдралд яарч тэвдэх үед ухасхийн аваад хэрэглэх бэлэн цэхээний эмийн зүйлгүй, юу ч хамаагүй дэргэдээ байснаа авч хэрэглэхчээ тус болсон нэгий нь өөр хоорондоо дамжуулан хэлэлцдэг болсноор домын аман уламжлал үүсжээ.

Хардомд хэрэглэдэг юм нь хүний байгаа орчны хамгийн энгийн зүйл байдаг. Тэр юм нь нүүдлийн нөхцөлд хэрэглэхэд хамгийн сайн зохицдог учраас нүүдэлчдийн эмнэлэг домнолын хэрэглэгдэхүүн болсон байжээ. Тэр үеийг төсөөлөн бодоход хүмүүс онол арга зүйн талаар сэтгэн бодох боломжгүй байсан нь тодорхой.

Түүхийн урт хугацаанд хүний оюун сэтгэлгээ хөгжиж, хуримталсан туршлага баян болсны сацуу мал амьтны үзүүлэх нөлөө их болж нүүдэлчдийн оюуны мэдлэг тэлснээр тэд мал амьтанд зориуд хийсэн ажиглалт, туршилтын үр дүнгээ хүн эмчлэх загвар болгож ашигладаг байсан нь аналогич оюун дүгнэлт хоёрыг уялдуулан хэрэглэсэн байдаг гэж хэлэх боломжтой юм.

Эртний монголчууд санамсаргүй тохиолдлоор өөрөө ч мэдэлгүй юмнаас зайлж гарахыг "зол заяа" гэсэн хоршоо үгээр илэрхийлдэг байжээ. Зол болов, золтой сүйд болсонгүй, зол заяаны эрхээр, заяатай төрсөн хүн, заяатай хүн гэх мэтээр тэд оюун санаанаас гадуур болдог золгүй тохиолдлоос эсэн мэнд гарахыг зол заяаны эрхээр болдог үйл явдал гэж үздэг байсан бололтой.

Балар эртний үед хардомд онолын гэх юмгүй зөвхөн ажиглалтын мэдлэгт түшиглэдэг байжээ. Тэр үеийн сэтгэлгээтэй байсан монголчуудын анагаах ухааны сэтгэлгээнд дорно дахины анагаахын онол арга зүй нөлөөлж, монгол анагаах ухааны сэтгэлгээ хөгжихөд зохих нэмэр болсон байна.

Хүндээр өвчилсөн, бэртсэн хүнийг байгаа газарт нь гэр барьж хөдөлгөөнгүй байлгаж асардаг, өвчтөний бие хөнгөн бол зөөн тээвэрлэдэг байжээ. Тэгээд домын ёсонд нүүдэллэн явах ёсонд тохирсон өвчтөний сувилгаа, тээвэрлэх аргатай байжээ.

Өвчтөний бие их муу, халдвартай өвчин хүрсэн, төрөх хүний байгаа гэрийн зөв талын үүдэнд, гэрийн дээд хошлонд дээс уяж, хөл хорьсны тэмдэг болгодог. Тэгж дээс уясан гэрт гадны хүн ордоггүй ёстой байжээ.

Монголчууд галуун хөтөвч, туулай хөтөвч, нугасан хөтөвч гэдэг хэд хэдэн хөтөвчтэй байсан нь цөм хэвтрийн өвчтөнд зориулан хэрэглэдэг байжээ. Монголчууд хар цай, ясны шөл,

шар тосоор өвчтөний бие цэвэрлэж тойлоход хэрэглэж арчиж угаах, тосолж илдэг асаргаатай байжээ. Модон гуурс, цоорт ургамлаар соруул хийж өндий чадалгүй болсон хүнийг хооллож ундалдаг байжээ. Өвчтөний ташаа жийрэглэхэд хөдөс, нэхий, хялгас, үнсэн живх хэрэглэдэг байжээ.

Хардомд өвчтөн тээвэрлэх хэд хэдэн аргатай байдаг. Үүнд: тэргэнд суулгах, арагинд суулгах, дөрөөвчлөх, дүүрэх аргаар унаагаар тээвэрлэдэг байжээ. Бас өвчтөнийг үүрэх, тэврэх, дамнах, ханалах, сугадах, түших аргаар түүнийг явганаар зөөдөг байсан зэргийг нэрлэж болно.

Хардом нь мянга мянган жилийн туршлагын хуримтлал юм. Түүний эмчилгээний аргаас уламжлал болсон нь олон мянган /бидний бүртгэлд 3626/ зүйл байгаагийн сацуу бас түүнээс хүн амьтанд тустай эмчилгээний сонгомол арга болж чадаагүй нь мартагдаж ирсэн бололтой.

Бидний үед домоос уламжлан үлдсэн эмчилгээний зүйлд мартагдахгүй байх тодорхой шалтгаан байна.

1. Дом ямар нэг хэмжээний ашигтай байдгаас;
2. Дом үүсэж хөгжсөн нүүдлийн иргэншил, түүний орчинд Монголд байгаа учраас;
3. Дом үүсэж дэлгэрсэн эмнэлгийн анхны тусламжийн хэлбэр нь нүүдэлчдийн аж байдалд зөв, оновчтой арга байснаас;
4. Домын эмчилгээнд хэрэглэдэг зүйл нь дан байгалийн гаралтай байдгаас;
5. Эмнэлэг үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаа зэргийг дурдаж болно.